



**МОНГОЛБАНКНААС МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛЧДИЙН ДУНД
ЗОХИОН БАЙГУУЛДАГ “ШИЛДЭГ ЭДИЙН ЗАСГИЙН НИЙТЛЭЛ”
УРАЛДААНЫ УДИРДАМЖ (2017 оны III улирал)**

НЭГ. ЗОРИЛГО

Монголбанк эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчдийн ур чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор эдийн засгийн нийтлэлийн уралдааныг улирал бүр зохион байгуулж байна. Эдийн засаг, мөнгөний бодлогын талаар өндөр түвшинд бичиж, энгийн ойлгомжтой хэлбэрээр олон нийтэд түгээх мэдлэг чадвартай сэтгүүлчдийн тоо нэмэгдсэнээр энэхүү сэдвээр үнэн бодит мэдээлэл нийгэмд хүрэх боломж нэмэгдэнэ.

ХОЁР.СЭДЭВ: ЭДИЙН ЗАСАГ БА ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ

Аливаа улс оронд төрөөс хэрэгжүүлж буй нэг чухал эдийн засгийн бодлого болох мөнгөний бодлогыг төв банкууд хариуцдаг. Өнөөдрийн байдлаар ихэнх төв банкуудын хувьд мөнгөний бодлогын үндсэн зорилт нь урт хугацааны үнийн тогтвортой байдал болдог. Харин энэхүү зорилтоо хэр амжилттай биелүүлэх эсэх нь төв банк улс төрийн нөлөөнөөс хэр ангид үйл ажиллагаа явуулахаас ихээхэн шалтгаалж буйг харуулсан судалгаа олон бий. Төв банкны хараат бус байдлыг хэмжихдээ зорилгын хараат бус байдал, арга хэрэгслийн хараат бус байдал, хууль эрх зүйн хараат бус байдал, үйл ажиллагааны хараат бус байдал гэх мэт хэмжүүрүүдийг ашигладаг. Эдгээр хэмжүүрээр хэмжсэн төв банкны хараат бус байдлын индекс өндөр орнуудад инфляци нам дор, тогтвортой түвшинд хадгалдагддаг зүй тогтол бий. Ийнхүү нэг талаас төв банкны бие даасан байдлыг баталгаажуулахын зэрэгцээ нөгөө талаас төв банкны зорилтыг илүү нарийвчлан тодорхой болгох, ил тод байдлыг хангуулах, сайн засаглалын тогтолцоотой болгох зэрэг нь төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлж, мөнгөний бодлогын үр дүнтэй байдлыг дээшлүүлдэг. *Төв банкны хараат бус байдал эдийн засагт хэрхэн нөлөөлдөг талаар судалгаа, бодит жишээ хослуулсан бүтээлийг дараах шалгуурт нийцүүлэн бичиж оролцохыг урьж байна.*

ГУРАВ. ШАЛГАРУУЛАЛТ

✓ **Шагнал:**

I байр: 500,000 төгрөг + Өргөмжөл

II байр: 400,000 төгрөг + Өргөмжөл

III байр: 300,000 төгрөг + Өргөмжөл

✓ **Материал хүлээн авах хугацаа:** 2017.09.28 (Баасан) 18.00 цаг хүртэл essay@mongolbank.mn хаягаар хүлээн авна (Subject мөрөнд Сэтгүүлчийн нэр, Ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллага,).

✓ **Тэмцээний үр дүнг зарлах хугацаа:** 2017.10.10 (Мягмар)

✓ Шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, сошиал сувгуудаар олон нийтэд түгээнэ

ДӨРӨВ. НИЙТЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

✓ Нийтлэлийг 800-1000 үгэнд багтаан бичих;

✓ Судалгаа, тоо баримттай байх;

- ✓ Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- ✓ Нийтлэл бичих ерөнхий бүтцийг баримталсан байх;
- ✓ Бусдын бүтээлийг хуулбарлаагүй байх;
- ✓ Нийтлэлийн бичгийн стандарт:
 - Үсгийн фонд: Times New Roman;
 - Үсгийн хэмжээ: 12;
 - Мөр хоорондын зай: 1,5;
 - Margins: top 2 cm, bottom 2 cm, left 3 cm, right 1.5 cm.
- ✓ Нүүр хуудсанд өөрийн овог нэр, ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагын нэр, холбоо барих 2 утас, и-мэйл хаягыг бичих.

ТАВ. НИЙТЛЭЛИЙГ ДҮГНЭХ ШАЛГУУР

- ✓ Нийтлэлийг дараах шалгуураар дүгнэнэ:

	Оноо
Ерөнхий шаардлага	
<i>Цаг баримтлал /18:00 цагаас хоцорсон бол -10 оноо/</i>	10
<i>Үгийн тоо /800-1000 үг/</i>	5
<i>Бичгийн стандарт /Фонт, үсгийн хэмжээ, маржин.../</i>	5
Асуултад хариулсан байдал	
<i>Төв банкны хараат бус байдлыг тайлбарласан байдал</i>	10
<i>Төв банкны хараат бус байдлын ач холбогдлыг тайлбарласан байдал (Эдийн засагт үзүүлэх нөлөөлөл)</i>	10
Эссений чанар	
<i>Үг үсгийн алдаа</i>	5
<i>Найруулга зүй</i>	5
<i>Логик дэс дараалал</i>	10
<i>Судалгаа/Тоо баримт ашигласан байдал</i>	10
<i>Энгийн ойлгомжтой байдал</i>	10
<i>Уншихад сонирхолтой байдал</i>	10
<i>Оригиналь санаа /давтагдаагүй/</i>	10
Нийт	100

Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Б” байр
Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв
МОНГОЛБАНК

Дэлгэрэнгүй мэдээллийг www.mongolbank.mn веб хуудаснаас
 болон (976) 11-310119 утсаар лавлана уу.